

ӨМНӨХ ҮГ

Монгол улсад Шинжлэх ухааны байгууллага үүсэн байгуулагдсаны 97 жил, Хими, химийн технологийн хүрээлэн байгуулагдсаны 57 жилийн ой тохиож буй энэ агшинд тус хүрээлэнгийн Байгалийн нэгдлийн химийн лаборатори байгуулагдсаны 45 жилийн ой болж байна. Энэ ойг тохиолдуулан тус лабораторийн үүсэл хөгжил, түүхэн замнал, эрдэмтэн судлаачдын бүтээл туурвилыг тус хүрээлэнгийн эрхлэн гаргадаг “Эрдэм Шижилгээний Бүтээл” сэтгүүлийн тусгай дугаарыг та бүхний анхааралд толилуулж байна. Энэхүү тусгай дугаарт тус лабораторийн ажилтнуудын судалгааны үр дүнгийн тойм өгүүллээс гадна энэ чиглэлээр ажиллаж буй эрдэмтдийн бүтээлийг нийтлүүлсэн болно.

Химийн хүрээлэнгийн захирлаар ажиллаж байсан нэрт эрдэмтэн, химич Т.Балдангийн санаачлагаар 1973 онд ШУА-ийн Химийн хүрээлэнд Ургамлын физиологийн идэвхт нэгдлийн химийн судалгааны тасаг анх 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан нь одоогийн Байгалийн нэгдлийн химийн лабораторийн суурь болсон юм. Захирал доктор Т.Балдан, доктор Я.Жамъянсан нарын удирдлагаар шинэхэн байгуулагдсан тасгийн анхны эрдэм шинжилгээний ажилтнаар Д.Батсүрэн, Д.Сэлэнгэ, Ц.Бямбаа, М.Дэлэгмаа нар ажиллаж, ургамлын химийн судалгаа шинжилгээний ажил эхэлснээс хойш өдгөө 45 жил болж байна.

Монгол улсад ургамлын бодисын химийн судалгааг эхлэн хөгжүүлэн дэлгэрүүлэхэд дорвитой хувь нэмэр оруулж байгаа үе үеийн судлаач, эрдэмтэн нартаа, мөн химийн салбарыг хөгжүүлэхэд мэдлэг чадвараа дайчлан ажиллаж буй эрдэмтэн, судлаач, ШУА болон тус хүрээлэнгийн үе үеийн удирдлага нартаа гүн талархал илэрхийлье.

Тусгай дугаарт бүтээлээ ирүүлсэн эрдэмтэн багш нар болон судлаачдад талархал илэрхийлье.

ЭРДЭМ НОМЫН ХУР БУУЖ,
ЭРДЭМ СУДЛАЛЫН ОЛОЛТ ДЭЛГЭРЭХ БОЛТУГАЙ

**Байгалийн нэгдлийн химийн лабораторийн эрхлэгч, Төрийн соёрхолт
Академич, Шинжлэх ухааны доктор Д.Батсүрэн**